



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
161 дүгээр сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Боловсролын газраас хандивласан нийт 35,000,000 (гучин таван сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 161 дүгээр сургууль (Б.Балжинням)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн Ерөнхий боловсролын 161 дүгээр сургууль (Б.Балжинням)-д үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны .04. дүгээр сарын ...26.. -ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт



Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Ерөнхий боловсролын 161 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага		
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
1	Компьютер (иж бүрэн)	site	2022.01.05	Сайн	ш	10	3,500,000.00	35,000,000.00	БНСУ-ын Сөүл хотын Боловсролын газар	Хандив	
тоног төхөөрөмжийн дүн									35,000,000.00		
Нийт хөрөнгийн дүн									35,000,000.00		